



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 8/107

Улаанбаатар хот

Г Энхийг сахиулагчдын өдрийг
Тэмдэглэн өнгөрүүлэх тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралтын 2.1.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 140 дугаар тогтоол, 2019 оны 200 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас баталсан "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр", Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас зохион байгуулагдаж байгаа "Бидний бахархал" төслийн хүрээнд дүүргийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас Нэгдсэн үндэсний байгууллагын мандаттай энхийг дэмжих ажиллагаа болон Олон улсын хамтарсан энхийг сахиулах ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүнийг дүүргийн хэмжээнд сурталчлан алдаршуулах үйл ажиллагааг дүүргийн Соёлын ордонд 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (дэд хурандаа Ш.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай.


2. Дүүргийн ерөнхий боловсролын "Хангай цогцолбор сургууль"-ийн ахлах ангийн сурагчдыг үйл ажиллагаанд оролцуулахыг сургуулийн захирал (Э.Соёмбобат)-т даалгасугай.

3. Энхийг сахиулагчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагаанд оролцох албан тушаалтны нэрийн жагсаалтыг нэгдүгээр, Энхийг сахиулагчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагаанд шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Энхийг сахиулагчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагаанд шаардагдах төсвийн зардал 374000 (Гурван зуун далан дөрвөн мянга) төгрөгийг дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц.)-т, үйл ажиллагааг зохион байгуулж дууссанаас хойш 5 хоногийн дотор дунг танилцуулж, зарцуулсан санхүүгийн тайланг ирүүлэхийг Цэргийн штаб (дэд хурандаа Ш.Бат-Өлзий)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СУХБОЛД

АДЛУ2023 он ажилзахирамж
1123000315